БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

2025.06.09

| № | | Үндэслэж буй бодлогын баримт бичиг | Санхүүжилт-ийн эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1.Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд | | | | | | | | |
| Зорилт 2. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, бохирдол багатай ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд | | | | | | | | |
| 1 | 2.2 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээ авах | 20.0 | Хур тунадасны хэмжээ | 2024 онд Ховд аймгийн 17 сумын нутаг дэвсгэрт 2024 оны 5-8 дугаар сарuudад аймгийн УЦУОШТ-ийн дэргэдэх “Ховд-Бороо-1, 2” экспедиц нийт 18 удаагийн гаралтаар 48 ширхэг пуужин харваж хур тунадасны хэмжээг 40-50 хувиар нэмэгдүүлэн ажилласан. | Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлсэн байна. | 2025 оны цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан харвах төхөөрөмж, суурь, пуужин, хээрийн экспедицийн цаг уурын хэмжил хийх багаж хэрэгслэлүүдийн иж бүрдлийг бэлэн болгон бэлтгэл ажлыг хангасан. Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолоор Байгаль хамгаалах сангийн төсөл хөтөлбөр арга хэмжээний 2.1 дэх заалтаар уаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг Говийн их Дархан цаазат газрын “Б” хэсэг болон Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор, Өндөр уулын бүс нутгаар хур тунадас нэмэгдүүлэх, бэлчээрийн ургамлын ургалтыг дэмжиж зуншлагын байдалд таатай нөлөө үзүүлэх, аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, ган цөлжилтөд нэрвэгдэж байгаа бүс нутгийн байгаль орчны төлөв байдлыг дэмжих зорилгоор 20 сая төгрөг шийдвэрлүүлсэнээс одоогоор 9 сая төгрөгний санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулж байна. ЦУОШГ-ын даргын 2025 оны 03-р сарын 10-ны өдрийн А/26 тоот тушаалын дагуу 3 сарын 12-нд Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хашаатын хөтөл гэдэг газар “Ноцоох зуух” ажиллуулж 2ш түлш шатааж ажилласан. Үүний үр дүнд Их нууруудын хотгор болон Өндөр уулын бүс нутгаар 0.0-7.0 мм хур тунадас орсон. Бэлчээрийн ургамлын ургалтанд угтвар чийг өгөхөд нөлөө үзүүлж | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажилласан.<br><br>03 дугаар сарын 10-наас 2 экспедиц нийт 8 удаа цаг агаарт зориудаар нөлөөлж Говийн их Дархан цаазат газрын “Б” хэсэг болон Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор, Өндөр уулын бүс нутгаар тус тус цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг амжилттай явуулсан. Хур тунадасны хэмжээг 40-45 хувиар нэмэгдүүлсэн байна. | |
| 2 | 2.5 | Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Үндэсний дасан зохицох төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах | - | 30 хувь<br>(2024 он) | - | 100 хувь | Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хамтран зохион байгуулж буй “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөлтэй танилцах, туршлага солилцох салбар форумыг 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдөр Завхан аймгийн Улиастай хотод зохион байгуулагдсан. Тус салбар форумд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймгийн “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох төлөвлөгөө боловсруулах” ажлын хэсгийн гишүүд Уур амьсгалын салбарын Ахлах техникч П.Энхжаргал, нислэгийн цаг уурын техникч Оюун тунгалаг нар оролцож, өөрсдийн төлөвлөгөөний төслөө танилцуулан сайн туршлагаа солилцсон байна. | 100 |
| 3 | 2.6 | Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого хийх зардлыг шийдвэрлэх | - | Санхүүжилтийг бүрэн шийдвэрлэсэн байдал (хувиар) | - | 100 хувь | Монгол Улсын “Агаарын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн А-479 тоот журмын дагуу Ховд аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн А/85 тоот захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь Ховд аймгийн хэмжээнд агаар бохирдуулж байгаа эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийн тооллогыг 2024 оны 12 дугаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сарын 03-наас 2025 оны 02 дугаар сарын 11-ний хооронд зохион байгуулж, дүнг нэгтгэн цахим санд бүртгэх ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.<br><br>Аймгийн засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь хяналтын тооллогын үйл ажиллагааны зардалд 6.300.000 төгрөгийн санхүүгийн зардлыг орон нутгаас шийдвэрлүүлж "Булган, Үенч, Алтай, Мөст, Цэцэг, Дарви, Зэрэг, Манхан, Ховд, Эрдэнэбүрэн, Буянт, Мянгад, Дөргөн, Чандмань" гэсэн 14 суманд ажиллаж, тухайн сумын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд арга зүйн зөвлөгөө өгч хяналтын тооллогыг хамтран хийсэн. | |
| 4 | 2.7 | Бүх сумдын түвшинд бэлчээрийн ургамлын явуул судалгааны зардлыг шийдвэрлэх | - | Санхүүжилтийг бүрэн шийдвэрлэсэн байдал (хувиар) | - | 100 хувь | Ховд аймгийн 17 сумын 84 зогсоол цэгт очиж ажиллах шатахууны 3.500.000 төгрөгний тооцоог гаргаж аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн. Одоогоор ажиглалтын хугацаа /8 сарын эхний 10 хоногт/ болоогүй учир зардал шийдвэрлэгдээгүй байна. | Хугацаа болоогүй |
| Зорилт 3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд | | | | | | | | |
| Зорилт4. Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ хангах хүрээнд | | | | | | | | |
| 5 | 4.2 | Эвдэрсэн газрын тооллого судалгааг хийж мэдээллийн санг баяжуулах | 8.0 | Хэрэгжилтийн хувь | 416. 43 га<br>(2023 он) | Эвдэрсэн газрын бүртгэл, судалгаа, орон зайн мэдээлэл шинэчлэгдэж мэдээллийн санд оруулсан байна. | Аймгийн хэмжээнд эвдэрсэн газрын тооллого судалгааны ажлыг хийхээр төлөвлөн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Тооллогын ажлыг III улиралд зохион байгуулна. Тооллого хийх хугацаа болоогүй судалгаа хийх тооцоо гаргаж тооллого хийх маршрут гаргаж хүсэлт хүргүүлсэн байгаа | 30 |

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд цаг уурын байгууллагад хамаарах 5 арга хэмжээг тусган хэрэгжүүлснээс 2 арга хэмжээ 100%, 1 арга хэмжээ 70%-тай, 1 арга хэмжээ 30%-тай, 1 арга хэмжээ хугацаа болоогүй, хэрэгжилт 75.0 %-тай байна.

ХЯНАСАН:
УМС ХЭЛТСИЙН ДАРГА [signature] М.БАЯРМАА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
УС СУДАЛЫН АХДАХ ТЕХНИКЧ [signature] П.ОТГОНЦЭЦЭГ